



**МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ**

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Олимпийн гудамж 2, Засгийн газрын VIII байр,  
Утас: 26-36-95, Факс: (976-11) 32-35-41  
И-мэйл: moh@moh.gov.mn, http://www.moh.gov.mn

2022.09.09 № 3/4016  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

Г ДОРНОД АЙМАГ ДАХЬ ЗҮҮН Г  
БҮСИЙН ОНОШИЛГОО,  
ЭМЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ДАРГА  
Д.ДОЛЖИН ТАНАА

Г Сургалтад нэр дэвшүүлэх тухай Г

ЖАЙКА-Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллагаас Монгол Улсад зориулж залуу ажилтнуудын (Knowledge Co-Creation Program Young Leaders) хөтөлбөрийн хүрээнд 2023 оны 01 сарын 11-28-ны өдрүүдэд Япон Улсад "Өргөн хүрээний бүс нутгийг хамарсан улсад эрүүл мэнд, эмнэлгийн яаралтай тусламж үйлчилгээг агаарын тээврээр үзүүлэх" сэдэвт сургалтыг зохион байгуулахаар төлөвлөж байгаа болно.


Сургалтад нэр дэвшигч нь 20-35 насны яаралтай тусламжийн тасагт ажилладаг байх шаардлага тавигдах ба шаардлага хангаж буй 1 ажилтаныг нэр дэвшүүлж, холбогдох анкетыг зааврын дагуу бөглүүлэн, шаардлагатай баримт бичгийн хамт 2022 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийн дотор тус яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Гадаад харилцааны хэлтэст ирүүлнэ үү.

Дээрх сургалт нь агаарын тээврийн эмнэлгийн яаралтай тусламж сэдвийн хүрээнд явагдах тул өөр чиглэлийн албан хаагч нэр дэвшүүлсэн тохиолдолд хасагдах болохыг анхаарна уу.

Сургалтын танилцуулга, хөтөлбөр, анкет болон бусад мэдээллийг хавсаргав.

Хавсралт: 26 хуудастай.

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН  
ГАЗРЫН ДАРГА *П.Эрхэмбаяр* П.ЭРХЭМБАЯР



**144226272**



## Залуучуудын сургалт (Монгол Улс)

GENERAL INFORMATION ON  
Health Operation and Management (Wide-Area Medical Service)  
Залуучуудын сургалт  
Эрүүл мэнд, эмнэлгийн тусламж үйлчилгээ  
(Өргөн хүрээний бүс нутгийг хамарсан эмнэлгийн тусламж үйлчилгээ)  
JFY2022

Сургалтын дугаар болон ID: NO. 202110246-J001 / ID. 202110246  
Сургалтын хугацаа: 2023.01.11~2023.01.28

Залуучуудад зориулсан энэхүү сургалтын хөтөлбөр (Knowledge Co-Creation Program (Young Leaders) нь Япон Улсын Засгийн газрын Хөгжлийн албан ёсны тусламжийн хүрээнд, Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА) тухайн орны засгийн газартай байгуулсан техникийн хамтын ажиллагааны хэлэлцээрт үндэслэн хэрэгжүүлдэг хамтын ажиллагааны нэг хэлбэр юм.

"JICA Knowledge Co-Creation (KCC) Program" гэдэг нэрний тухайд 2015 онд шинэчилсэн найруулагдсан "Хөгжлийн хамтын ажиллагааны ерөнхий зарчим"-д хөгжиж буй орнуудтай хамтран ажиллаж, харилцан суралцах талаар дараах байдлаар тодорхойлжээ. "Тухайн түнш орны бие даасан байдал, хүсэл сонирхол, өвөрмөц байдлыг хүндэтгэхийн зэрэгцээ ажлын талбар дахь практик арга барилд суурилж, яриа хэлэлцээ, хамтын ажиллагаагаар дамжуулан, тухайн оронд тохирсон, хөгжилд дэвшилд нь хувь нэмэр болохуйц зүйлийг хамтдаа бүтээх, цаашлаад хамтдаа суралцаж, Япон болон түнш орон хамтдаа хөгжин цэцэглэхэд чиглэсэн харилцааг бүрдүүлэхийг зорилт болгоно. Энэ нь хөгжиж буй орнуудын өөрсдийнх нь хүчин чармайлтыг дэмжиж, ирээдүйд бие даан хөгжихийг зорилго болгож ирсэн Японы хөгжлийн хамтын ажиллагааны сайхан уламжлал болно". Энэхүү санааг хөтөлбөрийн нэрэнд тусгасан юм.

## 1. Хөтөлбөрийн танилцуулга

### 1. Залуучуудын сургалтын хөтөлбөр

Энэхүү хөтөлбөрийг Японы Засгийн газрын техникийн хамтын ажиллагааны төлөвлөгөөнд үндэслэн, хөгжиж буй орнуудын хүний нөөцийг хөгжүүлэх зорилгоор ЖАЙКА хэрэгжүүлдэг.

Энэхүү хөтөлбөр нь ирээдүйд тухайн улс орныг хөгжүүлж, бүтээн байгуулах залуу боловсон хүчнийг Япон улсад урьж авчран, 18 хоногийн хугацаанд үндсэн мэргэшлийн сургалтад хамруулдаг ба ингэснээр,

- 1) Японы мэргэжлийн салбарын туршлагаас суралцаж технологийн талаарх ойлголттой болгож, залуу боловсон хүчний мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэхэд хувь нэмэр оруулах
- 2) Өөрийн орны тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхэд нь хувь нэмэр болохуйц мэдлэг мэдээллийг олгож, ухамсрыг дээшлүүлэхийг зорилго болгодог.

## 2. Сургалтын танилцуулга

### 1. Сургалтын сэдэв (сургалтын нэр)

Эрүүл мэнд, эмнэлгийн тусламж үйлчилгээ (Өргөн хүрээний бүс нутгийг хамарсан эмнэлгийн тусламж үйлчилгээ) (202110246-J001)

### 2. Япон дахь сургалтын хугацаа

2023.01.11~2023.01.28

### 3. Зорилтот бүс нутаг

Монгол Улс

### 4. Зорилтот байгууллага/ боловсон хүчин

Өргөн хүрээний бүс нутгийг хамарсан эмнэлгийн тусламж үйлчилгээний салбарын дараах ажилтнууд

- (1) Эрүүл мэндийн яамны өргөн хүрээний бүс нутгийг хамарсан эмнэлгийн тусламж үйлчилгээ хариуцсан төрийн албан хаагч
- (2) Онцгой байдлын ерөнхий газрын агаарын тээвэр хариуцсан төрийн албан хаагч
- (3) Улсын эмнэлгийн эмч

### 5. Сургалтад оролцогчдын тоо

10 хүн

### 6. Хэл

Монгол хэл

### 7. Хөтөлбөрийн зорилго

Японы өргөн хүрээний бүс нутгийг хамарсан эмнэлгийн тусламж үйлчилгээний тогтолцоог цогцоор нь ойлгож, энэхүү тогтолцоог

нэвтрүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны төлөвлөгөөг (Action plan) гаргана.

#### 8. Ерөнхий зорилго

Өргөн хүрээний бүс нутгийг хамарсан эмнэлгийн тусламж үйлчилгээ хөгжиж, бүс нутгийн эмнэлгийн тусламж үйлчилгээний хүртээмжийн ялгааг арилгах үндэс суурь тавигдана.

#### 9. Сургалтын зорилго (үр дүн)

- (1) Японы өргөн хүрээний бүс нутгийг хамардаг орон нутгийн эрүүл мэнд, эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлэх тогтолцоо, арга барилын талаар ойлголттой болох.
- (2) Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудын үүрэг, удирдлагын арга барил, тухайн байгууллагын хүний нөөцөө хөгжүүлэх арга барилын талаар ойлголттой болох.
- (3) Түргэн тусламжийн үйлчилгээнд нисдэг тэрэг ашиглах гэх мэтээр орон нутгийн эмнэлгийн тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулах талаар авах арга хэмжээ юу байж болох талаар төлөвлөж, хэлэлцэх.

#### 10. Сургалтын агуулга

##### (1) Лекц / Дадлага

- ① Японы засгийн газар болон орон нутгийн засаг захиргааны байгууллагын чиг үүрэг, эрүүл мэндийн тогтолцоо, эмнэлгийн яаралтай тусламжийн тухай лекц.
- ② Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудын чиг үүрэг болон удирдлагын арга зүйн тухай лекц.
- ③ Японы агаарын тээврийн эмнэлгийн яаралтай тусламжийн (EMS /Emergency Medical Services) үйл ажиллагаа, эмнэлгийн яаралтай тусламжийн (EMS) онгоц, түргэн тусламжийн нисдэг тэрэг зэргийн өнөөгийн байдал болон тулгамдаж буй асуудлын тухай лекц.

##### (2) Үзэж танилцах

- ① Бүс нутгийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний бааз болох эмнэлэг
- ② Түргэн тусламжийн тийрэлтэт онгоцны бааз болох эмнэлэг
- ③ Түргэн тусламжийн нисдэг тэрэгний бааз болох эмнэлэг
- ④ Онгоцны ангар
- ⑤ Япон соёлтой танилцах

##### (3) Хэлэлцүүлэг

- ① Сургалтын үр дүн болон цаашдын төлөвлөгөө, хэтийн төлөв зэргийг тусгасан судалгааны тайланг боловсруулж танилцуулах
- ② Өргөн хүрээний бүс нутгийн эрүүл мэнд, эмнэлгийн тусламж үйлчилгээг хариуцдаг яам, агентлаг болон эмнэлгийн ажилтнуудтай санал бодлоо солилцох

**<Сургалтын хөтөлбөр>**

Сар өдөр	Агуулга
1/11	Японд ирэх
1/12	ЖАЙКА-ийн бүртгэл, ерөнхий танилцуулга
1/13	Сургалтын хөтөлбөрийн танилцуулга / Засгийн газар болон орон нутгийн засаг захиргааны байгууллагын чиг үүрэг, эрүүл мэндийн тогтолцоо, эмнэлгийн яаралтай тусламж
1/14	Үзэж танилцах / Бие даан суралцах өдөр
1/15	Бие даан суралцах өдөр
1/16	Лекц "Бүс нутгийн эрүүл мэнд, эмнэлгийн тусламж үйлчилгээ" / Үзэж танилцах "Бүс нутгийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний бааз болох эмнэлэг"
1/17	Лекц "Японы агаарын тээврийн эмнэлгийн яаралтай тусламжийн (EMS /Emergency Medical Services) өнөөгийн байдал болон тулгамдаж буй асуудал" / Япон соёлтой танилцах "Cool Japan"
1/18	Үзэж танилцах газар руу хөдлөх
1/19	Лекц "Эмнэлгийн яаралтай тусламжийн (EMS) онгоц" / Үзэж танилцах "Түргэн тусламжийн тийрэлтэт онгоцны бааз болох эмнэлэг"
1/20	Төрийн байгууллагын (Эрүүл мэнд, Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яам, Их дээд сургуулийн харьяа эмнэлэг) ажилтнуудтай санал солилцох
1/21	Бие даан суралцах өдөр (Сургалтын тайлангаа боловсруулах)
1/22	Бие даан суралцах өдөр (Сургалтын тайлангаа боловсруулах)
1/23	Лекц "Японы түргэн тусламжийн нисдэг тэрэгний тухай" / Үзэж танилцах "Түргэн тусламжийн нисдэг тэрэгний бааз болох эмнэлэг"
1/24	Лекц "Японы онгоц болон нисдэг тэрэгний тухай" / Үзэж танилцах "Наканихон компанийн онгоцны ангар"
1/25	Сургалтын тайлангаа боловсруулж бэлтгэх / Санал бодлоо солилцох
1/26	Сургалтын тайлангаа илтгэж танилцуулах
1/27	Сургалтыг нэгтгэн дүгнэх / Сургалтын хаалтын ажиллагаа
1/28	Монгол руу буцах

\*Сургалтын хөтөлбөрт өөрчлөлт орох магадлалтай.

### 3. Сургалтад хамрагдах болзол, журам

#### 1. Сургалтад оролцох болзол

Дараах шаардлагыг хангасан ажилтныг сонгон шалгаруулж санал болгохыг хүсэж байна.

##### (1) Тавигдах шаардлага

Сургалтад оролцохоор хүсэлт гаргагч нь дараах шаардлагыг хангасан байна.

- 1) Доорх 3. (1)-д заасан журмын дагуу тухайн улсын засгийн газраас санал болгосон хүн байх
- 2) "5. Хавсралт" дахь сургалтын агуулгатай холбоотой салбарт ажилладаг байх
- 3) 20-35 настай байх
- 4) Монгол хэлээр чөлөөтэй ярьж, бичдэг байх
- 5) Хөтөлбөрт оролцохын тулд бие бялдар, сэтгэц эрүүл байх

##### (2) Боломжтой бол дараах шаардлагыг хангасан байх

- 1) Японд урьд нь ирж байгаагүй хүн байх
- 2) Их дээд сургууль төгссөн байх

#### 2. Сургалтад оролцохоор хүсэлт гаргах үед шаардагдах бичиг, баримт

##### (1) Хүсэлт гаргахад бөглөх маягт (Application form)

ЖАЙКА-ийн Монгол дахь төлөөлөгчийн газар болон Японы Элчин Сайдын яамнаас авах боломжтой. Маягт(Application form)-ыг гараараа бөглөх биш компьютероор шивж бөглөнө үү.

##### (2) Паспортын хуулбар

Сургалтын үеэр биедээ авч явах шаардлагатай. Паспорттой бол бөглөсөн маягтын хамт хуулбарыг нь ирүүлнэ үү. Паспорт байхгүй тохиолдолд паспорт авсныхаа дараа хуулбарыг нь аль болох хурдан ирүүлнэ үү.

Паспортын хуулбарт дараах мэдээлэл заавал орсон байх ёстой.

Үүнд: овог нэр, төрсөн он сар өдөр, харьяалал, хүйс, паспортын дугаар, хүчинтэй байх хугацаа

##### (3) Сургалтад оролцогчдын ажлын газрын холбогдох ажилтны холбоо барих хаяг, утас

Сургалт дууссаны дараа ЖАЙКА-аас сургалтад оролцогчдын ажлын газарт анкет явуулах бөгөөд "Залуучуудын сургалтад оролцогчдын талаарх анкетад хариулж, хөтөлбөр хэрэгжсэний дараах судалгаанд

хамтран ажиллахыг хүсье" гэсэн материалд холбогдох хүний холбоо барих хаяг, утас зэргийг бөглөж, сургалтад оролцох хүсэлтийн маягт (application form)-тай хамт ирүүлнэ үү. Сургалтад оролцогч эх орондоо буцаж ирсний дараа гарсан өөрчлөлт, сургалтаар сурч мэдсэн зүйлээ ажилдаа хэрхэн ашиглаж байгаа зэргийг ажиглаж мэдэх боломжтой дээд албан тушаалтан эсвэл боловсон хүчин хариуцсан ажилтан байх шаардлагатай. (Хавсралтыг уншина уу).

### **3. Сонгон шалгаруулах журам**

#### **(1) Шаардлагатай бичиг баримтыг бүрдүүлж ирүүлэх**

Тухайн орны засгийн газар нь, энэхүү сургалтад тохирох хүнийг тодруулж, шаардлагатай бичиг баримтыг хүн тус бүрээр бүрдүүлээд ЖАЙКА-ийн Төлөөлөгчийн газарт ирүүлнэ.

Бичиг баримтыг хүлээн авах эцсийн хугацаа: ЖАЙКА-ийн Монгол дахь Төлөөлөгчийн газраас лавлана уу.

ЖАЙКА-ийн Монгол дахь төлөөлөгчийн газар нь бичиг баримтыг хүлээн авсны дараа 2022 оны 10-р сарын 26-ны өдрийн (Лхагва) дотор ЖАЙКА-ийн төвд ирүүлнэ.

#### **(2) Сонгон шалгаруулалт**

Сургалтад оролцох хүсэлт гаргасан хүний ажлын газар нь тухайн хүнийг сургалтад оролцуулах хүсэл сонирхол өндөртэй байх тохиолдол сонгон шалгаруулалт хийхдээ харгалзан үзнэ.

Сургалтад оролцох хүсэлт гаргасан хүн нь цэргийн албан хаагч, эсхүл цэргийн холбоотой хүн байвал тусгайлан, нарийвчлан шалгасны үндсэн дээр сургалтад оролцуулж болох эсэх шийдвэрийг гаргана.

#### **(3) Сонгон шалгаруулалтын үр дүн**

2022 оны 11-р сарын 22 (Мягмар)-д ЖАЙКА-ийн Монгол дахь Төлөөлөгчийн газраар дамжуулан Монголын Засгийн газарт үр дүнгийн талаар мэдэгдэх болно.

### **4. Дүрэм, журам**

Сургалтад оролцогчид нь

- (1) Тогтсон сургалтын хөтөлбөрийг чанд мөрдөнө.
- (2) Оролцох сургалтыг өөрийн дураар өөрчилж болохгүй.
- (3) Японд байх хугацааг өөрийн дураар өөрчилж болохгүй.
- (4) Сургалтын хугацаанд гэр бүлийн гишүүдээ Японд авчирч болохгүй.
- (5) ЖАЙКА-аас тогтоосон нутаг буцах маршрутыг дагаж мөрдөнө.
- (6) Улс төрийн үйл ажиллагаа явуулах, ашгийн төлөө ажиллахыг хориглоно.

(7) Японы хууль тогтоомжийг дагаж мөрдөнө. Хууль тогтоомж зөрчсөн тохиолдолд тухайн зөрчлийн зэргээс хамаарч энэхүү сургалтад зарцуулагдсан зардлыг бүхэлд нь эсвэл нэг хэсгийг нь буцааж төлөх шаардлагатай болохыг анхаарна уу.

(8) Байрлах газрын дүрэм, журмыг дагаж мөрдөнө. Мөн ЖАЙКА-ийн бэлдсэн байранд байрлах ба өөрийн дураар байрлах газрыг өөрчилж болохгүй.



## 4. Сургалтын зохион байгуулалтын тухай

### 1. Сургалтыг зохион байгуулагч ЖАЙКА (JICA)

(1) Сургалтын төв: ЖАЙКА-ийн Чүбү сургалтын төв

(2) Хариуцсан ажилтан: Сүзүки Чие

([Suzuki.Chie.2@jica.go.jp](mailto:Suzuki.Chie.2@jica.go.jp), [cbictp1@jica.go.jp](mailto:cbictp1@jica.go.jp))

\*И-мэйл илгээхдээ энэхүү сургалтын дугаарыг (202110246-J001) гарчигт оруулна уу.

### 2. Японд ирэх

(1) Онгоцны тийз: ЖАЙКА-д зөвшөөрөгдсөн олон улсын нисэх онгоцны буудлаас Япон хүртэлх хоёр талын энгийн зэрэглэлийн тийзийг ЖАЙКА бэлтгэх болно.

(2) Аяллын даатгал: Даатгалын нөхөн олговорт зөвхөн Японд байх хугацаа л хамрагдана.

### 3. Японд байхдаа байрлах газар

ЖАЙКА нь сургалтад оролцогчдыг доорх газруудад байрлуулахаар зохицуулна.

ЖАЙКА-ийн Чүбү сургалтын төв

Үзэж танилцах газруудын ойролцоох зочид буудлууд

ЖАЙКА-ийн Чүбү сургалтын төвд хоосон өрөө байхгүй тохиолдолд ЖАЙКА өөр газар захиалж өгөх болно.

Япон дахь ЖАЙКА-ийн сургалтын төвүүдийн танилцуулгыг дараах URL хаягаас үзнэ үү.

<https://www.jica.go.jp/english/about/organization/domestic/index.html>

### 4. Тэтгэмж, зардал

ЖАЙКА нь дараах тэтгэмж, зардлыг хариуцна.

(1) Байр, хоол хүнс, өдөр тутмын амьжиргааны болон ном, сурах бичиг явуулах зардал

(2) Суралцах аяллын зардал (галт тэрэгний тасалбар)

(3) Японд ирсний дараа өвдсөн тохиолдолд эмчилгээний зардал (суурь өвчин, жирэмслэлт, шүдний эмчилгээний зардал орохгүй)

(4) Сургалтын материалын зардал зэрэг сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардал

Дэлгэрэнгүй мэдээллийг Япон явахын өмнө тарааж өгөх "KENSHU-IN GUIDE BOOK" товхимолоос уншиж танилцана уу.

### 5. Японд ирэхийн өмнөх зааварчилгаа, танилцуулга

Японд ирэхийн өмнө, Японд хэрхэн ирэх талаар болон сургалтын талаар ЖАЙКА-ийн Монгол дахь төлөөлөгчийн газар тайлбарлаж зааварчилгаа өгнө.

[Суралтын үйлчилгээний төлөө газрын  
хариуцаагчид тусламж үйлчилгээг илэрхийлж утас]

Ирэх өдөр	_____
Ирэх газар	_____
Утас	_____
Холбоо барих	_____
Холбоо барих	_____
Холбоо барих	_____

**Залуучуудын сургалтад оролцогчдын талаарх анкетад хариулж, хөтөлбөр хэрэгжсэний дараах судалгаанд хамтран ажиллахыг хүсье**

Залуучуудын сургалт дууссаны дараа, сургалтаар сурч мэдсэн зүйлээ ажилдаа хэрхэн ашиглаж, хэрэгжүүлж буй талаар сургалтад оролцогчдоос ЖАЙКА-аас анкетаар судалгаа авна. Судалгааны анкетыг сургалтад оролцогчдыг эх орондоо буцсаны дараа И-мэйлээр явуулах болно.

Судалгааны үр дүнг илүү бодитой болгох үүднээс сургалтад оролцогчдын ажлын газрын (дээд албан тушаалтан, боловсон хүчин хариуцсан ажилтан гэх мэт) холбогдох хүмүүсээс давхар анкетаар судалгаа авах ба сургалтад оролцогчдын ажилдаа хандах хандлагад гарсан өөрчлөлт, ур чадварын ахиц дэвшлийн талаар асууж тодруулах юм.

Иймээс ЖАЙКА-ийн анкетын судалгаанд оролцоход тохиромжтой албан тушаалтны холбоо барих хаяг, утас зэргийг доорх хүснэгтэд бөглөж өгнө үү.

Судалгааны анкетыг ЖАЙКА-ийн сургалт дууссанаас хойш 1 жилийн дотор сургалтад оролцогчид болон доорх хүснэгт дэх тухайн байгууллагын холбогдох хүмүүст И-мэйлээр шууд явуулах болно.

Хөтөлбөр хэрэгжсэний дараах судалгаанд оролцож, бидэнтэй хамтран ажиллахыг та бүхнээс хүсье!

**【Сургалтад оролцогчийн ажлын газрын холбогдох албан тушаалтны нэр, хаяг, утас】**

Овог нэр		
Албан тушаал		
Харьяа газар, хэлтэс		
Холбоо барих	Хаяг:	
	И-мэйл:	
	Утас:	Факс:

## Нэмэлт мэдээлэл

### **ЖАЙКА ба Хүний нөөцийн хөгжил**

ЖАЙКА нь 1974 онд байгуулагдсан цагаасаа эхлэн "Хүний нөөцийг хөгжүүлэх" гэсэн үзэл баримтлалд тулгуурлан мэргэжилтнүүдийг илгээх, техникийн хамтын ажиллагааны төслүүдийг хэрэгжүүлэх, хөгжлийн судалгааг хийх, сургалтад хамруулах, сайн дурын гишүүдийг илгээх зэргээр хамтын ажиллагаагаа өрнүүлж ирсэн.

Сургалтын хамтын ажиллагаа нь ЖАЙКА-ийн түүхэнд чухал үүрэг гүйцэтгэж ирсэн юм.

Сургалтын хамтын ажиллагаа нь Япон улсад хэрэгждэг бөгөөд хөгжлийн явцдаа хуримтлуулж ирсэн Японы нийгмийн мэдлэг туршлага, ур чадвараас суралцах, Японы түүх, соёлтой танилцах боломжийг олгодог. Сургалтад оролцогчид нь мэдлэг туршлага, ур чадварт суралцаж эх орондоо буцаж ирээд, өөрийн мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэхийн зэрэгцээ ажиллаж буй байгууллага, цаашлаад улсынхаа нийгмийн хөгжилд хувь нэмрээ оруулна хэмээн найдаж байна.

ЖАЙКА нь хөдөө аж ахуй, орон нутгийн хөгжил, жендер, байгаль орчны менежмент, боловсрол, эрүүл мэнд, дэд бүтэц, эрчим хүч, худалдаа, санхүү гэх мэт мэргэжлийн олон салбарыг хамарсан 460 орчим сургалт зохион байгуулдаг. Эдгээр сургалтын хөтөлбөрийг бодлого боловсруулж хэрэгжүүлэх болон үйлчилгээ үзүүлэх байгууллага төдийгүй эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагууд зэрэг бусад олон төрлийн байгууллагын тусгай хэрэгцээнд нийцүүлэн төлөвлөж, хэрэгжүүлдэг. Зарим хөтөлбөр нь хөгжлийн тулгамдаж буй нийтлэг асуудлууд болон улс орнуудын тодорхой нэг бүлэгт чиглэгдсэн байдаг.

### **Японы хөгжлийн туршлага**

Япон улс орчин үеийн шинэчлэл болон үйлдвэржилтийг амжилттай хэрэгжүүлсэн хамгийн анхны барууны бус улс (Америк, Европын орнууд бус) юм. Одоогоос 140 гаруй жилийн өмнөөс эхэлсэн энэхүү хөгжил нь, өндөр хөгжилтэй орнуудаас Япон болон японы ард түмэнд тохирсон мэдлэг, технологийг "оруулж ирээд сайжруулан тохируулах" гэсэн хандлагад суурилсан байлаа. Оруулж ирсэн мэдлэг, технологийг Японы бүс нутаг бүр өөрсдийн туршлага, хүчин чармайлтаараа сайжруулан засаж, суурьшуулж ирсэн юм. Бусад улс орноос олж авсан мэдлэг, технологийг Японы бүс нутаг бүрийн хэрэгцээ, нөхцөл байдалд зохицуулан Японы нийгэмд эцэст нь шингээж чадсан билээ.

Япон нь барууны орнуудаас (Америк, Европын орнууд ) ялгаатай нийгэм, соёлын тогтолцоотой бөгөөд Япон улсад сургалтад хамрагдсанаар та бүхэн

үүнийг мэдрэх боломжтой юм.

ЖАЙКА-ийн сургалтад оролцогчид нь Японд ирж, япончуудтай харилцаж, Японы нийгмийн тогтолцооны сайн тал төдийгүй муу талыг нь ч олж хараад Япончууд бидэнтэй санал бодлоо солилцоосой хэмээн бид хүсдэг. Иймээс ч ЖАЙКА-ийн сургалтад аль болох олон хүн хамруулахыг хүсдэг юм.



ЖАЙКА-ийн сургалтад оролцогчид нь Японд ирж, япончуудтай харилцаж, Японы нийгмийн тогтолцооны сайн тал төдийгүй муу талыг нь ч олж хараад Япончууд бидэнтэй санал бодлоо солилцоосой хэмээн бид хүсдэг. Иймээс ч ЖАЙКА-ийн сургалтад аль болох олон хүн хамруулахыг хүсдэг юм.